



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.Umnugovi@audit.mn](http://www.Umnugovi@audit.mn)

Өмнөговь аймаг

2025 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр  
Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn  
Аудитын менежер: Т.Хонгорзул  
Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn  
Ахлах аудитор: Ж.Болормаа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolormaaja@audit.gov.mn  
Аудитор: Ө.Болортуяа  
Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	Error! Bookmark not defined.
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл .....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	Error! Bookmark not defined.
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	Error! Bookmark not defined.
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	6
5.1 Төлбөрийн акт .....	7
5.2 Албан шаардлага .....	7
5.3 Зөвлөмж .....	7
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	8

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
СТА	Санхүүгийн тайлангийн аудит

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.14 № 276

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

"ӨМНӨГОВЬ ГУРВАНСАЙХАН ОРОН  
СУУЦНЫ КОРПОРАЦИ" ХХК-ЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Ж.ЭРДЭНЭБОЛД ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд 33,258.3 мянган төгрөгийн авлага барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй, завсрын аудитаар өгсөн албан бичгийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, 20.2.5 дахь заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан "Гэр хорооллын айл өрхийг төвлөрсөн усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход дэмжлэг үзүүлэх тухай журам"-ын дагуу 711,136.2 мянган төгрөгөөр 165 өрхийг цэвэр усны шугамд, 93 өрхийг бохир усны шугамд холбох ажлыг зохион байгуулсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж,

4625020557

аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 12,896,901.4 мянган төгрөгийн 110 айлын 4457.92 м2 байрыг бүртгэлд тусгаж, 64 иргэнтэй түрээсийн гэрээ байгуулсан байна.

#### **Бусад асуудал**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
3	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	834,369,113.26	2,143,825,737.61
4	Дансны авлага	6,050,000.00	6,050,000.00
5	ААНОАТ-ын авлага	625,832.18	625,832.18
6	Бусад авлага	29,317,261.37	26,582,501.37
8	Бараа материал	15,987,840.00	16,841,950.00
9	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	5,700,000.00
10	Бусад эргэлтийн хөрөнгө	64,076,825.00	124,016,825.00
13	Эргэлтийн хөрөнгийн дүн	950,426,871.81	2,323,642,846.16
15	Үндсэн хөрөнгө барилга	22,022,144,032.41	34,642,008,382.32
23	Биет бус хөрөнгө	1,650,000.00	1,320,000.00
24	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,023,794,032.41	34,643,328,382.32
25	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>22,974,220,904.22</b>	<b>36,966,971,228.48</b>
31	Татварын өр	-	29,244,269.24
35	Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой тооцоо	64,076,825.00	124,016,825.00
36	Урьдчилж орсон орлого	121,422,397.16	849,127,915.12
38	Бусад богино хугацаат өр төлбөр	252,554,460.79	388,698,925.79
41	Богино хугацаат өр төлбөрийн дүн	438,053,682.95	1,391,087,935.15
45	Хойшлогдсон татварын өр	21,974,254,401.66	34,528,814,148.06
48	Урт хугацаат өр төлбөрийн дүн	21,974,254,401.66	34,528,814,148.06
49	Өр төлбөрийн нийт дүн	22,412,308,084.61	35,919,902,083.21
51	Өмч: а) төрийн	8,000.00	8,000.00
59	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	561,904,819.61	1,047,061,145.27
61	Эздийн өмчийн дүн	561,912,819.61	1,047,069,145.27
62	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>22,974,220,904.22</b>	<b>36,966,971,228.48</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	1,036,292,356.00	1,312,001,799.00
2	Борлуулалтын өртөг	895,308,628.91	1,171,557,648.69
3	Нийт ашиг	140,983,727.09	140,444,150.31
5	Хүүний орлого	27,935,218.70	109,040,847.22
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	910,780.00
8	ХТӨр дансны ХЭХЗОрлого	315,702,225.91	537,954,901.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	184,874,128.77	249,288,094.46
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	299,747,042.93	539,062,584.07
19	Орлогын татварын зардал	29,974,704.29	53,906,258.41
20	Татвар дараах ашиг (алдагдал)	269,772,338.64	485,156,325.66
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	269,772,338.64	485,156,325.66

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
2	Мөнгөн орлогын дүн (+)	1,229,325,488.15	1,583,466,008.82

**Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

3	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,153,681,601.45	755,903,411.60
4	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	2,929,260.00
5	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	3,888,335.00
7	Татаас, санхүүжилтийн орлого /ЦБУсны хөнгөлөлт/	27,596,576.70	711,136,155.00
8	Бусад мөнгөн орлого /Хүүгийн орлого болон бусад/	48,047,310.00	109,040,847.22
9	Мөнгөн зарлагын дүн (-)	800,118,333.05	1,033,061,729.83
10	Ажиллагчдад төлсөн	101,920,100.00	132,358,141.00
11	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	33,691,942.36	39,517,850.00
12	Бараа материалын худалдан авахад төлсөн	38,231,071.10	31,675,633.66
16	Татварын байгууллагад төлсөн	39,072,798.59	37,887,676.17
18	Бусад мөнгөн зарлага	587,202,421.00	59,159,829.00
19	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	429,207,155.10	1,309,456,624.35
30	Мөнгөн зарлагын дүн (-)	9,752,500.00	-
31	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,752,500.00	-
37	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-9,752,500.00	-
52	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	419,454,655.10	1,309,456,624.35
53	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	414,914,458.16	834,369,113.26
54	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	834,369,113.26	2,143,825,737.61

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2023 . оны 12-р сарын 31 - ний үлдэгдэл	8,000.00	-	-	561,904,819.61	561,912,819.61
12	Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал /	-	-	-	485,156,325.66	485,156,325.66
17	2024 . оны .12.- р сарын 31-ний үлдэгдэл	8,000.00	-	-	1,047,061,145.27	1,047,069,145.27

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 13,312,255.2 мянган төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Ерөнхий журналаас орлогын тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй тулган баталгаажуулахад 140,064.021 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Ерөнхий ба удирдлагын зардлын бүртгэлийн дэлгэрэнгүйг тулган баталгаажуулахад ББӨ-т тусгах 10,143,223 төгрөг 51 мөнгийн зардал бүртгэсэн;
- Тайлант онд 13,162,047,937 төгрөг 16 мөнгөний үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон өр төлбөр хэсэгт илэрхийлээгүй;
- Жилийн эцсийн санхүүгийн тайлантай хамт тайлангийн тодруулга бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 1,207,645.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 11,010.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага их тул “Өөрчлөлттэй” дүгнэлт өглөө.

ӨМА-2025/001/НА-СТА-ОНӨҮГ

## 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

## 5.2 Албан шаардлага

1. Завсрын аудитаар Хадгаламжийн дансанд хөрөнгө байршуулахгүй, үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж ажиллах тухай албан бичиг өгсөн боловч хэрэгжилтийг хангаж ажиллаагүй 1,174,386,970.99 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Энэ нь Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 5/20 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг шинэчлэн батлах тухай"-ын 3 дугаар зүйлийн 3.5.4-д "орон сууцны эрэлтийг багасгаж, нийлүүлэлтийг ихэсгэх зорилгоор иргэдийн газрыг дахин төлөвлөх", 3.5.5-д "хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдахорон сууцанд хөрөнгө оруулалт хийх, орон сууц худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.

## 5.3 Зөвлөмж

Санхүүгийн байдлын тайланд тусгасан дансны авлага болон бусад авлага 33,258,333.55 төгрөг, урьдчилж төлсөн зардал 5,700.000 төгрөгийг тус тус тооцоо нийлсэн эсэх нь нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 10 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ерөнхий журналаас орлогын тайлангийн борлуулсан бүтээгдэхүүний өртөгтэй тулган баталгаажуулахад 140,064.021 төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	140,064.0			1	140,064.0	1	140,064.0				
Ерөнхий ба удирдлагын зардлын бүртгэлийн дэлгэрэнгүйг тулган баталгаажуулахад ББӨ-т тусгах 10,143,223 төгрөг 51 мөнгийн зардал бүртгэсэн	1	10,143.2			1	10,143.2	1	10,143.2				
Тайлант онд 13,162,047,937 төгрөг 16 мөнгөний үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон өр төлбөр хэсэгт илэрхийлээгүй	1	13,160,047.9			1	13,160,047.9	1	13,160,047.9				
Тайлант онд 13,162,047,937 төгрөг 16 мөнгөний үндсэн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хойшлогдсон өр төлбөр хэсэгт илэрхийлээгүй	1	0			1	0	1	0				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>13,312,255.2</b>			<b>4</b>	<b>13,312,255.2</b>	<b>4</b>	<b>13,312,255.2</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/Д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Дүн

Өмнөговь Гурвансайхан орон сууцны корпораци ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд  
хийсэн аудитын тайлан

1	Завсрын аудитаар Хадгаламжийн дансанд хөрөнгө байршуулахгүй, үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж ажиллах тухай албан бичиг өгсөн боловч хэрэгжилтийг хангаж ажиллаагүй үлдэгдэлтэй тайлагнасан байна	1	1,174,387.0			1	1,174,387.0					
2	Санхүүгийн байдлын тайланд тусгасан дансны авлага болон бусад авлага 33,258,333.55 төгрөг, урьдчилж төлсөн зардал 5,700.000 төгрөгийг тус тус тооцоо нийлсэн эсэх нь нотлогдохгүй байна	1	33,258.3					1	33,258.3			
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>1,207,645.3</b>			<b>1</b>	<b>1,174,387.0</b>	<b>1</b>	<b>33,258.3</b>			

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Хариуцлага тооцох албан шаардлага		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
1												
	<b>Дүн</b>											
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
1												
	<b>Дүн</b>											
	<b>Нийт дүн</b>								-			